ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Геронтологийн үндэсний төвийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

**Аудитын код:** СНАГ-2025/150/НА-СТА-ТШЗ

| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br>Улаанбаатар хот<br>2025 он | Санхүү, Нийцлийн аудитын газрын захирал,<br>тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг<br>Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn<br>Аудитын менежер: В.Эрдэнэцогт<br>Утас: 261885 Цахим хаяг: erdenetsogtv@audit.gov.mn<br>Аудитор: Б.Отгонцэцэг<br>Утас: 261628 Цахим хаяг: otgontsetsegb@audit.gov.mn<br>Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн :Баян ташаагийн эх Аудит ХХК<br>Захирал: Т.Хоролсүрэн<br>Утас: 99116028 Цахим хаяг: bte.audit@yahoo.com |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
Засгийн газрын IV байр, Бага тойруу 3,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: 26 04 37, Факс: (976-51) 26 42 30,
Цахим шуудан: info@audit.gov.mn,
Цахим хуудас: www.audit.mn

2025.03.28 № 07/1265
танай ____________ -ны № ____________ -т

ГЕРОНТОЛОГИЙН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ Р.ХИШИГЖАРГАЛ ТАНАА

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Геронтологийн үндэсний төвийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

**Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, заагврын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно. Тухайлбал:

- Эмнэлгийн тоног төхөөрөмж нийлүүлэх гэрээний дагуу хөрөнгө худалдан авахдаа тендерийн баримт бичигт тусгасан техникийн үзүүлэлтээс өөр үзүүлэлттэй 51,000.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмжийг зах зээлийн үнээс өндөр үнээр худалдан авсан;
- Тендер сонгон шалгаруулалтын баримт бичигт заасан шалгуурыг хангаагүй 3 аж ахуйн нэгж байгууллагыг сонгон шалгаруулж 424,855.2 мянган төгрөгийн худалдан авалт хийсэн;
- Өмнөх онд худалдаж авсан 18 нэр төрлийн 1,642 ширхэг 5,553.4 мянган төгрөгийн хугацаа нь дууссан эм, тариаг өмч хамгаалах байнгын комиссын хурлын тэмдэглэлгүй, устгалтын компанитай гэрээ байгуулаагүй устгасан;

зэрэг зөрчлүүд нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаар буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй байна.

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1, 13.7, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2, 16.5.4, “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1, 15 дугаар зүйлийн 15.1, 26 дугаар зүйлийн 26.4, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай



1525071319

хуулийн 67 дугаар зүйлийн 67.1, 67.2, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 гэсэн заалтуудтай нийцээгүй бөгөөд санхүүгийн тайлагналын эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

### Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Улсын төсвийн хөрөнгөөр баригдсан Геронтологийн үндэсний төвийн эмнэлгийн барилга нь 2024 оны 12 дугаар сард ашиглалтад орохоор гэрээтэй тул бэлтгэл ажлыг хангаж, улсын төсвийн хөрөнгөөр 623,729.1 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, 27,514.1 мянган төгрөгийн хангамжийн материалыг бэлтгэсэн боловч тус төвийн барилгыг улсын комисс хүлээж аваагүй байна.

### Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын дэмжлэгтэй Монгол улсад хэрэгжүүлэх “Эрүүл насжилт” арга хэмжээг дэмжих сургалт, уулзалт, хэлэлцүүлгийг зохион байгуулсны үр дүнд 2025-2028 онд хэрэгжүүлэх үндэсний арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулж, Эрүүл мэндийн яам, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамаар батлуулсан байна.

### Бусад асуудлын хэсэг

Тус төв нь тайлант онд 11 зорилтын хүрээнд 43 арга хэмжээг хэрэгжүүлэхээр гүйцэтгэлийн төлөвлөгөө батлуулж, гүйцэтгэлээр 92.6 хувийн биелэлттэй гэж тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

### Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮ, НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.НАРАНЧИМЭГ

АТА9693 9( .6109
9023030583

## 2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

*2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан*

*/Төгрөгөөр/*

| код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **583,099,070.22** | **348,551,224.03** |
| **31** | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | **309,642,410.50** | **17,248,880.31** |
| **31200** | **Банкинд байгаа бэлэн мөнгө** | **309,642,410.50** | **17,248,880.31** |
| **31210** | **Төгрөг** | **309,642,410.50** | **17,248,880.31** |
| 31215 | Нэмэлт санхүүжилтийн харилцах | 309,642,410.50 | 17,248,880.31 |
| **33** | **АВЛАГА** | **93,941,404.79** | **158,427,173.80** |
| 33100 | Ажиллагчидтай холбогдсон авлага | 512,719.09 | |
| 33200 | Төлбөртэй үйлчилгээний авлага | 92,764,080.00 | 158,427,173.80 |
| **33500** | **Бусад авлага** | **664,605.70** | |
| 33510 | Байгууллагаас авах авлага | 664,605.70 | |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | **179,515,254.93** | **172,875,169.92** |
| **35100** | **Түүхий эд материал** | **51,909,012.97** | **42,661,781.95** |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 80,000.00 | 80,000.00 |
| 35130 | Эм боох материал | 51,829,012.97 | 42,581,781.95 |
| **35400** | **Хангамжийн материал** | **127,606,241.96** | **130,213,387.97** |
| 35410 | Бичиг хэргийн материал | 869,580.00 | 472,290.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 20,916,288.90 | 17,401,904.00 |
| 35430 | Сэлбэг хэрэгсэл | 1,140,000.00 | 1,140,000.00 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 2,538,488.69 | 967,013.20 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 102,141,884.37 | 110,232,180.77 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **722,652,059.72** | **1,382,557,735.93** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | **722,652,059.72** | **1,382,557,735.93** |
| **39200** | **Биет хөрөнгө** | **663,044,979.46** | **1,305,593,903.55** |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 125,920,677.50 | 125,920,677.50 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (90,159,231.60) | (102,178,417.92) |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 37,200,000.00 | 168,000,000.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | (15,410,589.05) | (25,400,589.05) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж(компьютер) | 759,855,759.42 | 1,290,928,653.13 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (248,019,225.18) | (395,907,593.70) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 117,186,572.40 | 287,858,486.00 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (23,528,984.03) | (43,627,312.41) |
| **39300** | **Биет бус хөрөнгө** | **59,607,080.26** | **76,963,832.38** |
| 39301 | Програм хангамж | 1,470,000.00 | 1,470,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | (664,999.74) | (958,999.62) |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 58,802,080.00 | 76,452,832.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **1,305,751,129.94** | **1,731,108,959.96** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **740,904.54** | **86,289,247.83** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | **740,904.54** | **86,289,247.83** |
| **41300** | **Өглөг** | **740,904.54** | **86,289,247.83** |
| 41310 | Ажилчидтай холбогдсон өглөг | 176,606.32 | 2,286,247.83 |
| 41320 | Бараа үйлчилгээний зардлын өглөг | 486,994.22 | |
| **41360** | **Бусад өглөг** | **77,304.00** | **84,003,000.00** |
| 41361 | Байгууллагад төлөх өглөг | | 84,003,000.00 |
| 41362 | Хувь хүмүүст төлөх өглөг | 77,304.00 | |

| | | | |
|---|---|---|---|
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **1,305,010,225.40** | **1,644,819,712.13** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | **1,305,010,225.40** | **1,644,819,712.13** |
| 51100 | Засгийн газрын оруулсан капитал | 478,903,308.00 | 478,903,308.00 |
| 511001 | Төрийн өмч | 478,903,308.00 | 478,903,308.00 |
| **51200** | **Хуримтлагдсан үр дүн** | **696,608,613.73** | **1,036,418,100.46** |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 696,608,613.73 | 696,608,613.73 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | | 339,809,486.73 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 129,498,303.67 | 129,498,303.67 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **1,305,751,129.94** | **1,731,108,959.96** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

*2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан*

*/төгрөгөөр/*

| Код | Үзүүлэлт | ӨМНӨХ ОН | ТАЙЛАНТ ОН |
|---|---|---|---|
| **I** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **2,137,128,461.72** | **2,708,853,344.11** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **176,600,548.72** | **224,560,680.11** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | **176,600,548.72** | **224,560,680.11** |
| **120004** | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | | **439,116.00** |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | | 439,116.00 |
| 120009 | Бусад орлого | | 630,000.00 |
| 120017 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө | 138,875,648.52 | 223,059,177.71 |
| 120018 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал | 37,724,900.20 | 432,386.40 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **1,960,527,913.00** | **2,484,292,664.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | **842,200,500.00** | **1,854,758,466.00** |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 842,200,500.00 | 1,854,758,466.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | **1,118,327,413.00** | **629,534,198.00** |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | 133,756,353.00 | 12,615,596.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 278,576,000.00 | |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 15,681,900.00 | 13,449,428.00 |
| 131107 | Эрүүл мэндийн даатгалын сангийн нэмэлт орлого | 690,313,160.00 | 603,469,174.00 |
| **II** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **1,626,576,664.25** | **2,369,043,857.38** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **1,626,576,664.25** | **2,369,043,857.38** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **1,547,458,469.65** | **1,910,115,086.51** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **1,022,770,201.21** | **1,355,276,275.47** |
| 210101 | Үндсэн цалин | 651,930,037.59 | 821,756,991.27 |
| 210102 | Нэмэгдэл | 176,009,947.62 | 171,226,452.20 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 81,325,246.00 | 105,522,000.00 |
| 210104 | Урамшуулал | 113,504,970.00 | 256,770,832.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **129,899,996.14** | **159,161,652.77** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 90,126,275.28 | 109,685,525.66 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 10,412,102.74 | 13,832,630.63 |

| | | | |
|---|---|---|---|
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 8,377,507.56 | 7,156,123.79 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1,869,160.47 | 5,592,493.12 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 19,114,950.09 | 22,894,879.57 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **60,725,799.83** | **72,109,807.68** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 8,632,823.54 | 7,200,522.45 |
| 210302 | Түлш, халаалт | 4,216,472.97 | 2,874,228.70 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 2,808,320.32 | 3,015,894.53 |
| 210304 | Байрны түрээс | 45,068,183.00 | 59,019,162.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **45,992,646.55** | **32,145,123.04** |
| 210401 | Бичиг хэрэг | 3,742,740.00 | 3,543,606.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 13,483,733.81 | 8,765,780.94 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 7,768,397.52 | 7,521,655.20 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 2,759,940.00 | 2,400,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 18,237,835.22 | 9,914,080.90 |
| **2105** | **Нормативт зардал** | **39,590,756.35** | **41,071,739.70** |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 34,977,556.35 | 37,322,639.70 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 4,613,200.00 | 3,749,100.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **15,841,402.00** | **10,487,400.00** |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 434,500.00 | |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 2,027,900.00 | |
| 210604 | Урсгал засвар | 13,379,002.00 | 10,487,400.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **65,993,620.00** | **5,000,000.00** |
| 210702 | Дотоод албан томилолт | 65,993,620.00 | 5,000,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **32,803,684.93** | **35,825,838.00** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 27,344,237.93 | 24,973,650.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 2,000,000.00 | 5,000,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 436,200.00 | 1,139,700.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 195,252.00 | 228,916.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 15,000.00 | 0.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 423,000.00 | 1,651,800.00 |
| 210807 | Газрын төлбөр | 1,012,000.00 | 1,421,062.00 |
| 210809 | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | 1,377,995.00 | 1,410,710.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **133,840,362.64** | **199,037,249.85** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 24,542,569.00 | 8,747,366.75 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 1,256,924.00 | |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 108,040,869.64 | 190,289,883.10 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **79,118,194.60** | **458,928,770.87** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **55,045,300.00** | **42,020,365.72** |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 54,645,300.00 | 38,890,365.72 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 400,000.00 | 3,130,000.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | **24,072,894.60** | **416,908,405.15** |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 24,072,894.60 | 416,908,405.15 |
| **III** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)** | **510,551,797.47** | **339,809,486.73** |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

*2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон*

*/Төгрөгөөр/*

| Код | Үзүүлэлт | ӨМНӨХ ОН | ТАЙЛАНТ ОН |
|---|---|---|---|
| **I** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)** | **1,968,795,208.50** | **2,418,629,570.20** |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **1,968,795,208.50** | **2,418,629,570.20** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | **842,200,500.00** | **1,854,758,466.00** |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 842,200,500.00 | 1,854,758,466.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | **1,126,594,708.50** | **563,871,104.20** |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | 133,756,353.00 | 12,615,596.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 278,576,000.00 | |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 116,713,275.50 | 13,449,428.00 |
| 131107 | Эрүүл мэндийн даатгалын сангийн нэмэлт орлого | 597,549,080.00 | 537,806,080.20 |
| **II** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **1,537,849,998.00** | **2,167,889,718.79** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **1,537,849,998.00** | **2,167,889,718.79** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **1,458,731,803.40** | **1,708,960,947.92** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **1,023,033,745.10** | **1,349,564,610.98** |
| 210101 | Үндсэн цалин | 701,954,993.28 | 800,325,698.79 |
| 210102 | Нэмэгдэл | 141,035,933.26 | 170,868,596.18 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 63,198,290.40 | 98,741,357.50 |
| 210104 | Урамшуулал | 116,844,528.16 | 279,628,958.51 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **129,704,746.92** | **160,794,226.26** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 91,980,564.04 | 113,746,539.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 9,807,329.15 | 13,172,026.59 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 7,754,744.56 | 6,809,628.85 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1,800,257.00 | 5,311,825.57 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 18,361,852.17 | 21,754,206.25 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **60,665,739.83** | **68,587,098.25** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 8,572,763.54 | 7,200,522.45 |
| 210302 | Түлш, халаалт | 4,216,472.97 | 2,874,228.70 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 2,808,320.32 | 3,015,894.53 |
| 210304 | Байрны түрээс | 45,068,183.00 | 55,496,452.57 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **34,911,433.55** | **24,216,751.40** |
| 210401 | Бичиг хэрэг | 3,435,300.00 | 2,676,700.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 14,575,052.50 | 6,844,400.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 7,041,420.05 | 7,521,655.40 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 2,934,440.00 | 2,664,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 6,925,221.00 | 4,509,996.00 |
| **2105** | **Нормативт зардал** | **65,003,519.00** | **16,619,695.00** |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 32,789,119.00 | 12,994,495.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 32,214,400.00 | 3,625,200.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **18,231,912.00** | **35,735,006.40** |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 1,065,000.00 | 5,749,300.00 |
| 210602 | Тавилга | | 18,006,806.40 |

| | | | |
|---|---|---|---|
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 3,167,000.00 | |
| 210604 | Урсгал засвар | 13,999,912.00 | 11,978,900.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **66,313,620.00** | **5,000,000.00** |
| 210702 | Дотоод албан томилолт | 66,313,620.00 | 5,000,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **50,767,887.00** | **38,524,233.43** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 44,288,635.00 | 27,765,305.43 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 2,000,000.00 | 5,000,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 436,200.00 | 1,139,700.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 155,252.00 | 178,916.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 55,000.00 | 50,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 198,000.00 | 2,248,050.00 |
| 210807 | Газрын төлбөр | 1,012,000.00 | 1,421,062.00 |
| 210809 | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | 2,622,800.00 | 721,200.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **10,099,200.00** | **9,919,326.20** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 8,371,200.00 | 9,919,326.20 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 1,728,000.00 | |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **79,118,194.60** | **458,928,770.87** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **55,045,300.00** | **42,020,365.72** |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 54,645,300.00 | 38,890,365.72 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 400,000.00 | 3,130,000.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | **24,072,894.60** | **416,908,405.15** |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 24,072,894.60 | 416,908,405.15 |
| **III** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)** | **430,945,210.50** | **250,739,851.41** |
| **V** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)** | **121,323,200.00** | **543,133,381.60** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **121,323,200.00** | **543,133,381.60** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | **121,323,200.00** | **543,133,381.60** |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 121,323,200.00 | 543,133,381.60 |
| **VI** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)** | **(121,323,200.00)** | **(543,133,381.60)** |
| **VIII** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)** | **309,622,010.50** | **(292,393,530.19)** |
| 101 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 20,400.00 | 309,642,410.50 |
| 20 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 309,642,410.50 | 17,248,880.31 |

**2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан**

*2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон*

/ төгрөгөөр/

| Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|
| **2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **478,903,308.00** | **129,498,303.67** | **186,056,816.26** | **794,458,427.93** |
| Дахин илэрхийлсэн үлдэгдэл | **478,903,308.00** | **129,498,303.67** | **186,056,816.26** | **794,458,427.93** |
| Тайлант үеийн үр дүн | | | 510,551,797.47 | 510,551,797.47 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| **2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **478,903,308.00** | **129,498,303.67** | **696,608,613.73** | **1,305,010,225.40** |
| Дахин илэрхийлсэн үлдэгдэл | **478,903,308.00** | **129,498,303.67** | **696,608,613.73** | **1,305,010,225.40** |
| Тайлант үеийн үр дүн | | | 339,809486.73 | 161,352,197.85 |
| **2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **478,903,308.00** | **129,498,303.67** | **1,036,418,100.46** | **1,644,819,712.13** |

**2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан**

*2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон*

төгрөгөөр/

| | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|---|
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **1,866,547,200.00** | **1,437,850,060.85** | **428,697,139.15** | **77.0** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **1,866,547,200.00** | **1,437,850,060.85** | **428,697,139.15** | **77.0** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **1,812,736,100.00** | **1,395,829,695.13** | **416,906,404.87** | **77.0** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **1,595,651,700.00** | **1,233,699,704.62** | **361,951,995.38** | **77.3** |
| 210101 | Үндсэн цалин | 799,214,300.00 | 800,325,698.43 | (1,111,398.43) | 100.1 |
| 210102 | Нэмэгдэл | 478,621,800.00 | 170,868,596.18 | 307,753,203.82 | 35.7 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 175,073,200.00 | 98,741,357.50 | 76,331,842.50 | 56.4 |
| 210104 | Урамшуулал | 142,742,400.00 | 163,764,052.51 | (21,021,652.51) | 114.7 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **199,456,500.00** | **147,155,464.60** | **52,301,035.40** | **73.8** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 135,630,300.00 | 101,935,591.27 | 33,694,708.73 | 75.2 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 15,956,500.00 | 12,657,806.98 | 3,298,693.02 | 79.3 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 7,978,300.00 | 6,552,519.03 | 1,425,780.97 | 82.1 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 7,978,400.00 | 5,100,528.59 | 2,877,871.41 | 63.9 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 31,913,000.00 | 20,909,018.73 | 11,003,981.27 | 65.5 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **4,159,200.00** | **4,159,199.71** | **0.29** | **100.0** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 2,434,200.00 | 2,550,975.15 | (116,775.15) | 104.8 |
| 210302 | Түлш, халаалт | 759,500.00 | 519,286.56 | 240,213.44 | 68.4 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 965,500.00 | 1,088,938.00 | (123,438.00) | 112.8 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **2,500,000.00** | **896,000.00** | **1,604,000.00** | **35.8** |
| 210807 | Газрын төлбөр | 2,500,000.00 | 896,000.00 | 1,604,000.00 | 35.8 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 10,968,700.00 | 9,919,326.20 | 1,049,373.80 | 90.4 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 10,968,700.00 | 9,919,326.20 | 1,049,373.80 | 90.4 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 53,811,100.00 | 42,020,365.72 | 11,790,734.28 | 78.1 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 53,811,100.00 | 42,020,365.72 | 11,790,734.28 | 78.1 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 50,678,800.00 | 38,890,365.72 | 11,788,434.28 | 76.7 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 3,132,300.00 | 3,130,000.00 | 2,300.00 | 99.9 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **1,866,547,200.00** | **1,854,758,466.00** | **11,788,734.00** | **99.4** |
| 1310 | Улсын төсвөөс санхүүжих | **1,866,547,200.00** | **1,854,758,466.00** | **11,788,734.00** | **99.4** |
| 131001 | Улсын төсвөөс санхүүжих | **1,866,547,200.00** | **1,854,758,466.00** | **11,788,734.00** | **99.4** |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | | | |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | | | | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | БАЙГУУЛЛАГЫН ТОО | | | | |
| 62 | АЖИЛЛАГСАДЫН ТОО | 52 | 45 | 7 | 86.5 |
| 620001 | Удирдах ажилтан | 1 | 1 | - | 100.0 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 41 | 36 | 5 | 87.8 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 10 | 8 | 2 | 80.0 |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

*2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон*

төгрөгөөр/

| код | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **I** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **844,165,300.00** | **856,264,634.39** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **844,165,300.00** | **856,264,634.39** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **844,165,300.00** | **856,264,634.39** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **129,358,400.00** | **115,864,906.00** |
| 210105 | Урамшуулал | 129,358,400.00 | 115,864,906.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **16,169,800.00** | **13,638,762.02** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 10,995,500.00 | 11,810,947.73 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 1,034,900.00 | 514,219.61 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,293,600.00 | 257,109.82 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 258,700.00 | 211,296.98 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 2,587,100.00 | 845,187.88 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **75,410,600.00** | **64,427,898.54** |
| 210301 | Гэрэл цахилгаан | 6,201,600.00 | 4,649,547.30 |
| 210302 | Түлш, халаалт | 3,227,000.00 | 2,354,942.14 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 1,899,600.00 | 1,926,956.53 |
| 210304 | Байрны түрээс | 64,082,400.00 | 55,496,452.57 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **31,384,000.00** | **24,216,751.40** |
| 210401 | Бичиг хэрэг | 3,435,600.00 | 2,676,700.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 7,857,000.00 | 6,844,400.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 8,316,400.00 | 7,521,655.40 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 3,000,000.00 | 2,664,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 8,775,000.00 | 4,509,996.00 |
| **2105** | **Нормативт зардал** | **18,333,600.00** | **16,619,695.00** |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 13,500,000.00 | 12,994,495.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 4,833,600.00 | 3,625,200.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **523,133,800.00** | **578,868,388.00** |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 364,833,800.00 | 405,520,000.00 |
| 210602 | Тавилга | 85,100,000.00 | 161,369,488.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 3,500,000.00 | |
| 210604 | Урсгал засвар | 69,700,000.00 | 11,978,900.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **7,647,200.00** | **5,000,000.00** |
| 210702 | Дотоод албан томилолт | 7,647,200.00 | 5,000,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **42,727,900.00** | **37,628,233.43** |

| | | | |
|---|---|---|---|
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 28,719,100.00 | 27,765,305.43 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 5,000,000.00 | 5,000,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 1,200,000.00 | 1,139,700.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 220,300.00 | 178,916.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношилгоо | 50,000.00 | 50,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 4,560,000.00 | 2,248,050.00 |
| 210807 | Газрын төлбөр | 1,012,000.00 | 525,062.00 |
| 210809 | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | 1,966,500.00 | 721,200.00 |
| **II** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **844,165,300.00** | **563,871,104.20** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | **11,622,000.00** | **26,065,024.00** |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | | 12,615,596.00 |
| 1200041 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажилагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 11,622,000.00 | 13,449,428.00 |
| 134002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 832,543,300.00 | 537,806,080.20 |
| IV | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | 309,642,410.50 |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | | 17,248,880.31 |

## 3. АУДИТААР ИЛЭРСЭН АЛДАА, ЗӨРЧЛИЙН НЭГТГЭЛ

3.1 Аудитаар нийт 496,110.8 мянган төгрөгийн зөрчил илэрснээс, 6,727.4 мянган төгрөгийн зөрчилд 3 төлбөрийн акт, 489,383.4 мянган төгрөгийн зөрчилд 5 албан шаардлага хүргүүлж, зөрчлийг давтан гаргахгүй байх 2 зөвлөмж өгсөн.

## Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| Тус төв нь “Гүн Хабсуу” ХХК-тай том оврын болон суудлын автомашиныг хадгалах түрээсийн гэрээ байгуулж 2,500.0 мянган төгрөгийг шилжүүлсэн, тус компани нь түрээслүүлэх гараашгүй бөгөөд түрээсийн гэрээ нь хүчин төгөлдөр байх баримт бичгийн шаардлагыг хангаагүй, гэрээний эх хувь байхгүй байна | 1 | 2,500.0 | 1 | 2,500.0 | | | | - | | | | |
| Тус төв нь хугацаа дуусах дөхсөн гэх үндэслэлээр тушаал, шийдвэргүй 10 нэр төрлийн 1068 ширхэг 3,563.7 мянган төгрөгийн үнэ бүхий эмийг 2,840.0 мянган төгрөгөөр “Монос” ХХК-д худалдан борлуулж, төлбөрийг няравын хувийн дансаар хүлээн авч, зарцуулсан байна. | 1 | 3,563.6 | 1 | 3,563.7 | | | | | | | | |
| Тус төвийн нэр бүхий 2 ажилтанд ур чадварын нэмэгдэл 663.7 мянган төгрөгийг илүү бодож олгосон байна. | 1 | 663.7 | 1 | 663.7 | | | | - | | | | |
| Тус төв нь 2023 онд худалдаж авсан 18 нэр төрлийн 1642 ширхэг 5,553.4 мянган төгрөгийн хугацаа нь дууссан эм тариаг төвийн ерөнхий захирлын 2024 оны 10 дугаар сарын 18-ны өдрийн А/56 тоот тушаалаар өмч хамгаалах байнгын комиссын хурлын тэмдэглэл үйлдээгүй, устгалтын компанитай гэрээ байгуулаагүй устгасан байна | 1 | 5,553.4 | | | 1 | 5,553.4 | | | | | | |
| Тайлант онд Космостек Монгол ХХК-иас эмнэлгийн тоног төхөөрөмж нийлүүлэх гэрээний дагуу хөрөнгө худалдан авахдаа тендерийн баримт бичигт тусгасан техникийн үзүүлэлтээс өөр үзүүлэлттэй 51,000.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмжийг зах зээлийн үнээс өндөр үнээр худалдан авсан байна. | 1 | 51,000.0 | | | 1 | 51,000.0 | | | | | | |
| Тус төв нь худалдан авах ажиллагааны тендерийн баримт бичигт заасан 2022, 2023 онуудад ижил төстэй бараа нийлүүлсэн туршлагын талаарх мэдээлэл, ажил | 1 | 424,855.2 | | | 1 | 424,855.2 | | | | | | |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| гүйцэтгэсэн гэрээ, гэрээ дүгнэсэн акт, нийлүүлэх барааны үнийн санал, бараа нийлүүлэх хуваарь, нийгмийн даатгал, татварын тодорхойлолттой байх шалгуурыг хангаагүй 3 аж ахуй нэгж байгууллагыг сонгон шалгаруулж 424,855.2 мянган төгрөгийн худалдан авалт хийсэн байна. | | | | | | | | | | | | |
| Тус төв нь тайлант онд “Жастчандмана” ХХК-тай 4,000.0 мянган төгрөгийн Сургалт, хоол үйлдвэрлэл, угаалгын тоног төхөөрөмж нийлүүлэх гэрээ байгуулсан бөгөөд тус гэрээний техникийн тодорхойлолт тусгаснаас өөр нэр төрлийн тоног төхөөрөмж нийлүүлсэн байна. | 1 | 4,000.0 | | | 1 | 4,000.0 | | | | | | |
| Тус төвийн Ерөнхий захирал хот дотор албан тушаалын суудлын автомашин хэрэглэж 3,974.8 мянган төгрөгийн шатахуун зарцуулсан байна. | 1 | 3,974.8 | | | 1 | 3,974.8 | | | | | | |
| Үндсэн хөрөнгийн дансанд элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн үлдэх өртөггүй 51,673.6 мянган төгрөгийн хөрөнгийн цаашид ашиглах хугацаа, үнийг шинэчлэн тогтоож, холбогдох байгууллагад хүргүүлж шийдвэрлээгүй байна. | 1 | | | | | | 1 | | | | | |
| Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын чанарын болон төлбөрийн хяналтаар тус төвийн баримтын бүрдүүлэлтэд тавих хяналт хангалтгүйгээс /цахим хяналтын хасагдал 4,783.6 мянган төгрөг/ шалтгаалан ЭМДС-аас авах санхүүжилтийг нэхэмжилсэн дүнгээс 4,783.6 мянган төгрөг буюу 0.8 хувийн санхүүжилт хасагдсан бөгөөд нягтлан бодох бүртгэлд бүртгэж, санхүүгийн тайланд тайлагнахгүй байна. | 1 | | | | | | 1 | | | | | |
| **Дүн** | **10** | **496,110.8** | **3** | **6,727.4** | **5** | **489,383.4** | **2** | **-** | **-** | **-** | | |

3.2 АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитаар илэрсэн 517,365.0 мянган төгрөгийн 1 зөрчилд албан шаардлага хүргүүлсэн.

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| *Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил* | | | | | | |
| Шилэн дансны цахим системд цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 517,365.0 мянган төгрөгийн 3 мэдээллийг байршуулаагүй, өмнөх оны аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна. | 1 | 517,365.0 | 1 | 517,365.0 | | - |
| **Дүн** | **1** | **517,365.0** | **1** | **517,365.0** | | **-** |